

**ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**

2025 оны 06 дугаар сарын 17-ны өдөр, Мягмар гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	0
Хуралдааны товч тэмдэглэл:	1-3
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	4-12
1. Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй хууль, тогтоолын төслүүдийг чуулганаар хэлэлцүүлэх эсэх асуудал	4-5
2. Төрийн албаны зөвлөлийн гишүүний албан тушаалд нэр дэвшигчийн сонсголын тайлан	5-12

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы
Төрийн байгуулалтын байнгын хорооны 06 дугаар сарын 17-ны өдөр
/Мягмар гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Ж.Бат-Эрдэнэ ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 25 гишүүнээс 15 гишүүн хүрэлцэн ирж, 60.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 15 цаг 18 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Чөлөөтэй: С.Амарсайхан, С.Бямбацогт, Б.Батбаатар, Т.Доржханд, Л.Оюун-Эрдэнэ, Н.Учрал, Л.Гантөмөр, Э.Одбаяр, Ц.Туваан, О.Цогтгэрэл.

Нэг.Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй хууль, тогтоолын төслүүдийг чуулганаар хэлэлцүүлэх эсэх асуудал

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, мөн албаны референт Б.Баярсайхан нар байлцав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7-д “Энэ хуулийн 5.1-д заасан жагсаалтад ороогүй хууль, тогтоолын төсөл өргөн мэдүүлснийг Зөвлөлийн саналыг харгалзан Төрийн байгуулалтын байнгын хороо хэлэлцэж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн бол чуулганаар хэлэлцүүлнэ.” гэж заасны дагуу өргөн мэдүүлсэн төсөл бүрээр санал хураалт явуулав.

Ж.Бат-Эрдэнэ: 1.Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин нарын 11 гишүүнээс 2025.06.10-ны өдөр өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 1
Бүгд: 14
92.9 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин нарын 40 гишүүнээс 2025.06.12-ны өдөр өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 2
Бүгд: 15
86.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Уг асуудлыг 15 цаг 21 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Төрийн албаны зөвлөлийн гишүүний албан тушаалд нэр дэвшигчийн сонсголын тайлан

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дэд дарга Б.Энх-Амгалан, Төрийн албаны зөвлөлийн гишүүнд нэр дэвшигч Ц.Амартөгс, Л.Золзаяа, Б.Төгсцэнгэл нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, мөн албаны референт Б.Баярсайхан нар байлцав.

Төрийн албаны зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчийн танилцуулгыг Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дэд дарга Б.Энх-Амгалан, Төрийн албаны зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчийн сонсголын тайланг Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар нар танилцуулав.

Нэр дэвшигч болон танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар, Б.Пүрэвдорж, Д.Амарбаясгалан, Ц.Сандаг-Очир нар үг хэлэв.

Ж.Бат-Эрдэнэ: 1.Бүрэн эрхийн хугацаа дууссантай холбогдуулан Бадамцоогийн Идэрчулууныг Төрийн албаны зөвлөлийн гишүүнээс чөлөөлөхийг дэмжье гэсэн нууц санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 4
Бүгд: 15
73.3 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Бүрэн эрхийн хугацаа дууссантай холбогдуулан Должингийн Баатарсайханыг Төрийн албаны зөвлөлийн гишүүнээс чөлөөлөхийг дэмжье гэсэн нууц санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 3
Бүгд: 15
80.0 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Бүрэн эрхийн хугацаа дууссантай холбогдуулан Цэнддаваагийн Амартөгсийг Төрийн албаны зөвлөлийн гишүүнээс чөлөөлөхийг дэмжье гэсэн нууц санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 4
Бүгд: 15
73.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Ж.Бат-Эрдэнэ: 1.Лхагвасүрэнгийн Золзаяаг Төрийн албаны зөвлөлийн гишүүнээр томилохыг дэмжье гэсэн нууц санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 4

Бүгд: 15
73.3 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Цэнддаваагийн Амартөгсийг Төрийн албаны зөвлөлийн гишүүнээр томилохыг дэмжье гэсэн нууц санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 4
Бүгд: 15
73.3 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Бадамдоржийн Төгсцэнгэлийг Төрийн албаны зөвлөлийн гишүүнээр томилохыг дэмжье гэсэн нууц санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 3
Бүгд: 15
80.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар Улсын Их Хурлын чуулганы хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 15 цаг 45 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 27 минут үргэлжилж, 25 гишүүнээс 15 гишүүн хүрэлцэн ирж, 60.0 хувийн ирцтэйгээр 15 цаг 45 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Ж.БАТ-ЭРДЭНЭ

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН
БАЙГУУЛАХ ХЭЛТСИЙН
ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 06 дугаар сарын 17-ны өдөр, Мягмар гараг
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар” танхим, 15 цаг 18 минут

ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Ж.Бат-Эрдэнэ: Байнгын хорооны эрхэм гишүүдийн амар амгаланг айлтгая. Ингээд хүрэлцэн ирсэн гишүүдийг танилцуулъя. Оюунсайханы Алтангэрэл гишүүн ирсэн байна. Баярмагнайн Баярбаатар гишүүн ирсэн. Сархадын Зулпхар гишүүн ирсэн. Бөхчулууны Пүрэвдорж гишүүн ирсэн. Лувсанцэрэнгийн Энх-Амгалан гишүүн ирсэн. Дашзэгвийн Амарбаясгалан гишүүн ирсэн. Жудагийн Баярмаа гишүүн ирсэн. Одсүрэнгийн Номинчимэг гишүүн ирсэн. Цэндийн Сандаг-Очир гишүүн ирсэн. Жадамбын Бат-Эрдэнэ, Энхбатын Болормаа гишүүн ирсэн. Нямтайширын Номтойбаяр гишүүн ирсэн. Гончигдоржийн Уянгахишиг гишүүн ирсэн. Ингээд Байнгын хорооны ирцийг танилцуулж дууслаа.

Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж ирц бүрдсэн тул Төрийн байгуулалтын байнгын хорооны 2025 оны 6 дугаар сарын 17-ны өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. 2 асуудал хэлэлцэнэ.

1.Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй хуулийн төслүүдийг чуулганаар хэлэлцүүлэх эсэх асуудал

2.Төрийн албаны зөвлөлийн гишүүдийн албан тушаалд нэр дэвшигчийн сонсголын тайланг хэлэлцэнэ.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан асуулт асуух, санал хэлэх гишүүд байна уу. Алга байна. Ингээд хэлэлцэх асуудалдаа оръё.

Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй хуулийн төслүүдийг чуулганаар хэлэлцэх эсэхийг шийдвэрлэх тухай.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5.7-д энэ хуулийн 5.1-д заасан жагсаалтад ороогүй хууль, тогтоолын төсөл өргөн мэдүүлснийг зөвлөлийн саналыг харгалзан Төрийн байгуулалтын байнгын хороо хэлэлцэж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн бол чуулганаар хэлэлцүүлнэ гэж заасан.

Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн төсөл бүрээр санал хураалт явуулна. Гишүүд санал хураалтад бэлдье.

1.Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин нарын 11 гишүүнээс 2025 оны 6 сарын 10-ны өдөр өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7 дахь хэсэгт заасны дагуу чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалтад 14 гишүүнээс 13 гишүүн оролцож, 92,9 хувиар санал дэмжигдлээ.

2.Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин нарын 40 гишүүнээс 2025 оны 6 сарын 12-ны өдөр өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7 дахь хэсэгт заасны дагуу чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалтад 15 гишүүнээс 13 гишүүн оролцож, 86,7 хувиар санал дэмжигдлээ.

Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй хуулийн төслүүдийг чуулганаар хэлэлцүүлэх эсэхийг шийдвэрлэх тухай хуулийн төслийг хэлэлцэж дууслаа.

15.21 цаг.

Дараагийн асуудалдаа оръё.

Төрийн албаны зөвлөлийн гишүүний албан тушаалд нэр дэвшигчийн сонсголын тайлан

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 133 дугаар зүйлийн 133.4.энэ хуулийн 133.1-д заасан хугацаа өнгөрснөөс хойш ажлын 5 өдрийн дотор дараах ажиллагааг хийнэ. 133.4.3 эрх бүхий этгээдийн санал, сонсголын тайланг Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэн санал, дүгнэлт гаргана гэж заасан байгаа. Мөн Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 111 дүгээр зүйлийн 111.4-д Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанд гишүүд эрх бүхий албан тушаалтны санал, Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан түүнчлэн нэр дэвшигчээс асуулт асууж, үг хэлж болно гэж заасан байгаа.

Төрийн байгуулалтын байнгын хорооны 2025 оны 5 дугаар сарын 28-ны өдрийн 6 дугаар тогтоолоор нэр дэвшигчийн сонсголыг 2025 оны 6 дугаар сарын 17-ны өдөр явуулахаар товлож, Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатарыг сонсгол даргалагчаар сонгон, сонсголыг зохион байгуулсан. Энэхүү сонсголын тайланг сонсгол даргалагч, Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар танилцуулна. Нэр дэвшигчдийг урьж байна. Баярбаатар даргын гишүүний микрофоныг нээе.

Б.Баярбаатар: Төрийн албаны зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчийн сонсголын тайлангийн танилцуулга

Монгол Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооноос Төрийн албаны тухай хуулийн 68 дугаар зүйлийн 68.2 дахь хэсгийг үндэслэн Төрийн албаны зөвлөлийн гишүүнд Улсын Их Хурлын Тамгын газар, Монгол Улсын

Ерөнхийлөгчийн Тамгын газар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар тус бүр 1 хүнийг төрийн албан хаагчийн төлөөлөл 2 хүний нэр дэвшүүлж, Улсын Их Хурлаас нэр дэвшигчийн сонсгол хийж, томилно гэж заасны дагуу Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газраас нэр дэвшүүлсэн Лхагвасүрэнгийн Золзаяа, төрийн албан хаагчийн төлөөллөөс хамгийн өндөр оноо авч нэр дэвшүүлсэн Цэнддаваагийн Амартөгс, Бадамдоржийн Төгсцэнгэл нарыг дэвшүүлсэн.

Төрийн байгуулалтын байнгын хороо Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль, Нийтийн сонсголын тухай хуульд заасны дагуу Төрийн албаны зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчийн томилгооны сонсголыг зохион байгуулахтай холбогдуулан дараах ажиллагааг явуулсан болно.

1.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 130 дугаар зүйл, мөн хуулийн 131 дүгээр зүйлийн 131.1, 131.2 дахь хэсэгт заасны дагуу Төрийн байгуулалтын байнгын хорооны 2025 оны 5 дугаар сарын 28-ны өдрийн 06 дугаар тогтоолоор нэр дэвшигчийн сонсголыг 2025 оны 6 дугаар сарын 17-ны өдөр зохион байгуулахаар товлож, 14 хоногийн хугацаанд сонсголд оролцогчийг бүртгэх болон нэр дэвшигчээс асуух асуулт, нэр дэвшигчийн талаарх саналыг хүлээн авч, сонсголын зарыг олон нийтэд хүргэсэн.

2.Төрийн албаны зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчийн сонсголыг Улсын Их Хурлын гишүүн, Ёс зүй, дэгийн байнгын хороон дарга Баярбаатар, Сонсголд Төрийн байгуулалтын байнгын хорооны гишүүд, нэр дэвшигч Лхагвасүрэнгийн Золзаяа, Цэнддаваагийн Амартөгс, Бадамдоржийн Төгсцэнгэл нар оролцлоо.

3.Нэр дэвшигчийн сонсголд нэр дэвшүүлсэн байгууллага, сонсгол даргалагч нэр дэвшигчийн талаарх товч танилцуулга, үүний дараа нэр дэвшигч цг албан тушаалд томилогдсон тохиолдолд хийх ажил, нэр дэвшсэн үндэслэл, боловсрол, ажлын туршлага, тухайн албан тушаалд тавих шаардлагыг хангаж байгаа тухайгаа танилцуулж дууссаны дараа Байнгын хорооны гишүүд нэр дэвшигчээс асуулт асууж, үг хэлсэн болно.

4.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 133 дугаар зүйлийн 133.1 дэх хэсэгт заасны дагуу нэр дэвшигчийн сонсголд оролцсон гишүүд хаалттай хуралдаж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонх саналаар нэр дэвшигч Бадамдоржийн Төгсцэнгэлийг тухайн албан тушаалд тавигдах шаардлагыг хангасан гэж, Лхагсүрэнгийн Золзаяа, Цэнддаваагийн Амартөгс нарыг тухайн албан тушаалд тавих шаардлагыг хангаагүй гэж үзсэн болно.

Танилцуулга хийж дууслаа. Баярлалаа.

Ж.Бат-Эрдэнэ: Нэр дэвшигчдээ танилцуулъя. Лхагвасүрэнгийн Золзаяа, Цэнддаваагийн Амартөгс, Бадамдоржийн Төгсцэнгэл.

Одоо Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газраас нэр дэвшүүлсэн нэр дэвшигчийн талаарх танилцуулгыг Ерөнхийлөгчийн Тамгын газрын дэд дарга Б.Энх-Амгалан танилцуулна. Энх-Амгалан даргыг 2 номерт урьж байна. 2 номерын микрофон өгье.

Б.Энх-Амгалан: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Төрийн албаны тухай хуулийн 68 дугаар зүйлийн 68.2 дахь хэсэгт заасны дагуу Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газраас Лхагвасүрэнгийн Золзаяаг Төрийн албаны зөвлөлийн гишүүнд нэр дэвшүүлэх саналыг Улсын Их Хуралд танилцуулж байна.

Лхагвасүрэнгийн Золзаяа 1977 онд Улаанбаатар хотод төрсөн. Эхнэр 2 хүүхдийн хамт амьдардаг. 1995 онд Улаанбаатар хотын 10 жилийн 45 дугаар сургууль, 1997-2001 онд Тагнуулын ерөнхий газрын дээд сургуулийг төгсөж, эрх зүйч мэргэжил эзэмшсэн. Бизнесийн удирдлагын магистрын зэрэгтэй.

Золзаяа нь Тагнуулын ерөнхий газарт 2001-2005 онд орон нутгийн нэгжид ажилтан, 2005-2011 онд төвийн нэгжид ажилтан, ахлах ажилтан, тасгийн дарга, хэлтсийн дарга, 2011-2013 онд Авлигатай тэмцэх газарт ахлах ажилтан, 2013-2015 онд Тагнуулын ерөнхий газарт Газрын орлогч дарга, 2015-2019 онд Монгол Улсаас Бүгд Найрамдах Хятад Ард Улсад суугаа дипломат төлөөлөгчийн газруудад консул, дипломат ажилтан, 2019-2023 онд Тайпэй дахь Улаанбаатарын Худалдаа, эдийн засгийн төлөөлөгчийн газрын тэргүүн, 2023-2025 онд Тагнуулын ерөнхий газарт Газрын орлогч дарга, 2025 оноос Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын Хуулийн бодлогын газарт ахлах референтээр ажиллаж байна.

Золзаяа 2021 оноос хойш үндэсний аюулгүй байдал, гадаад харилцааны чиглэлээр ажилласан. Төрийн албаны туршлагатайг тодотгон үзэж, Төрийн албаны зөвлөлийн гишүүнээр томилуулахаар нэр дэвшүүлж байна.

Лхагвасүрэнгийн Золзаяаг Төрийн албаны зөвлөлийн гишүүнээр томилох асуудлыг холбогдох хууль, журмын дагуу хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Ж.Бат-Эрдэнэ: Нэр дэвшигчээс болон нэр дэвшигчийн сонсголын тайлангаас асуулт асууж, үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү. Пүрэвдорж гишүүн, Амарбаясгалан гишүүнээр тасаллаа. Баярбаатар гишүүн.

Б.Баярбаатар: Би 3 нэр дэвшигчийн сонсголыг даргалсан. 3 нэр дэвшигчийг аль алиныг нь дэмжиж байгаа. Төрийн албанд ажилласан туршлага, эзэмшсэн мэргэжил гээд олон зүйлүүд нь бас давуу тал болж харагдаж байна гэж бодож байгаа. Дээр нь Амартөгс нэр дэвшигч маань одоо Төрийн албаны зөвлөлийн гишүүнээр ажиллаж байгаа. Монгол Улсын ёс зүйн хороог бас толгойлж ажиллаж байгаа. Анхдагч хуулийг хэрэгжүүлэх гээд олон зүйлүүдийг бас хийж хэрэгжүүлж байгаа ажлынх нь хувьд бол үргэлжлүүлж ажиллах нь зөв байх гэсэн ийм байр суурийг бол илэрхийлээд явж байгаа.

Ер нь зүгээр цаашдаа одоо бид энэ Төрийн албаны зөвлөлийн энэ эрх мэдлийн асуудал, хууль, эрх зүйн зохицуулалтын асуудал, энэ Их Хурлаас томилогддог албан тушаалтнуудын эрх зүйн зохицуулалтын асуудлыг зөв зүйтэй гаргаж ирэхгүй бол хэтэрхий бид нар гүйцэтгэх засаглалтайгаа холилдоод, хяналт хэрэгжүүлэх зарчмаа алдаад явах нь өөрөө буцаад энэ төрийн албаны нэр хүндийг унагах, чадамжийг нь сулруулах ийм нөхцөл байдал руу ороод байна гэсэн ийм дүгнэлтэд хүрч байгаа юм.

Цаашлаад төрийн албаны бүтэц данхар боллоо. Данхар биш байна, зохимжгүй байна, зохимжтой байна гэсэн олон шүүмжлэлийг хүлээж байгаа. Тэгээд энэ бүгдийг бас нарийн судалж, судалгаан дээр үндэслэж асуудалд хандаарай гэдгийг бас та гуравтаа захиж хэлээд дэмжмээр байна.

Өнгөрсөн сонсгол дээр бас жоохон тоогүй маргаанууд бол үүссэн. Би энэ хажуу талд нь олон улсын хурал зохион байгуулж байгаа юм. Энэ Чингис хаан танхимд. Тэгээд тэнд ингээд би бас олон улсынхаа судлаачидтай уулзаад, судалгааны дүн гээд зүйл ярихад ер нь парламентын нэр хүндийг бол парламентын гишүүд нь өөрсдөө л унагадаг юм. Нэг унасан парламентын нэр хүнд эргэж босдоггүй юм гэдэг айхтар дүгнэлтийг бас сая танилцуулж байна. Тэгээд магадгүй өнгөрсөн 76 гишүүнтэй парламентад бол миний бие байгаагүй. Зүгээр тэр үед бие биеийгээ янз бүрийн нэр хочоор нь дуудсаар байгаад ингээд парламентынхаа нэр хүндийг унагаад, тэгээд өнөөдөр яг хариуцлага хүлээгээд явж байгаа хүн нь хэд юм бэ гээд харахаар одоо бас цөөхөн байгаад байдаг. Тэгэхээр энэ парламентад сууж байгаа парламентын гишүүд маань энэ парламентынхаа дархлааг сайжруулж, үйл ажиллагааг нь илүү ил тод болгож, нэр хүндийг нь өсгөдөггүй юм аа гэхэд хадгалах хэлбэр дээр бас хамтдаа чармайж ажиллах ёстой гэж боддог.

Хэн нэгэн шүүхээр хууль хяналтын байгууллагаар тогтоогдоогүй зүйлийг бас дуудаж, цол гуншин олгох нь буруу юм болов уу гэсэн хувь хүний байр суурь байгаа. Тэгээд ялангуяа Их Хурлын бүтцэд удирдах албан тушаал эрхэлж байгаа албан тушаалтнууд хоорондоо ийм ёс зүйгүй маргаан үүсгэх нь өөрөө их буруу гэж бодож байгаа. Хэвлэл мэдээллээр олон нийтэд явж байгаа энэ зүйл бол зарим нэгд нь бол таалагдах байх, зарим нэгд нь бол бас шүүмжлэлтэй хандагдах ийм нөхцөл байдал байгаа гэдгийг ярианыхаа төгсгөлд хэлье. Тэгээд 3 нэр дэвшигчээ дэмжиж байгаагаа илэрхийлье. Баярлалаа.

Ж.Бат-Эрдэнэ: Пүрэвдорж гишүүн.

Б.Пүрэвдорж: Төрийн албаны зөвлөлийнхөн өөр дээрээ эрхүүдийг авсаар байгаад одоо төрийн байгууллагуудын томилох эрхийг бүгдийг нь авчихсан. Дээрээс нь томилох эрхийг нь авчхаад, дээрээс нь төсвийнх нь эрх рүү өнгийж эхэлж байгаа. Төрийн албан хаагчдын зөвлөгөөнийг зохион байгуулна гэж яам болгоныг 20 сая төгрөг өг гэж байгаа. Дээрээс нь Төрийн албаны зөвлөлд яамнуудыг 20 сая төгрөгөөр зарим яамнуудад нь iPad авч өг гэж бичиг бичиж байгаа. Ийм юмнууд зөндөө байна. Тэгээд сая намайг үг хэлсэнтэй холбоотойгоор маш олон захидлууд ирж байна.

Тэгээд ер нь бол төрийн албанд хамаг хүнээ аваад хаачихсан. Тэгээд ерөөсөө тэнд ажил хийдэг хүн байхгүй. Тэрийг нь сольё гэхээр ерөөсөө солих ямар ч боломж байхгүй. Тэгээд залуу хүмүүсийг төрд орох тэр бүх боломж, нүх сүв нь бүгдээрээ хаагдчихсан ийм л байгаад байгаа шүү дээ.

Дээрээс нь Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 1 сарын 25-ны өдрийн 25 дугаар тогтоолоор баталсан журмаар ярилцлагад оруулдаг. Тэр ярилцлагад болохоор өөрсдөө унагаах хүнээ унагаагаад, авах хүнээ авдаг. Ийм байж байна. Ер нь бол Төрийн албаны зөвлөлийнхөн салбар зөвлөлийнхөн бол ажилд авах хүнээ л товллоод тэрэндээ тааруулж, төрийн албаны шалгалтуудаа авдаг. Тэгээд яг авах хүнээ л авдаг ийм болчихсон. Даргын чиг хараагаар явдаг болсон. Төрийн

албаны зөвлөлийн дарга нар өөрсдөө төрийн албандаа шалгараагүй байж байж хүмүүсийг солих, халах, томилох ийм шийдвэрүүдийг гаргадаг. Тэгээд төрийн албанд орсон хүмүүстээ зарим аймаг тэд нартаа зориулсан тусгай халамжуудыг бий болгож, ард иргэдээ ялгаварлах ийм хандлагууд маш их гаргаж байгаа.

Тэгээд ер нь бол овоо босгоогүй бол шаазгай юунд сууна гэж. Баярбаатар дарга өөрөө Их Хурлын дэгийн тухай хуулийн дагуу хүмүүсийг үгээ авсны дараа араас нь үг хэлүүлж энд янз янзын асуудал гаргасан шүү дээ. Та өөрөө Ёс зүй, дэгийн байнгын хорооны даргын хувьд ийм алдаа гаргаад.

Ер нь бол нэг хэсэг хүмүүс нь 5, 6 удаа төрийн албаны шалгалтад ороод тэнцэж чадахгүй уйлж унжаад явж байхад, нөгөө хэсэг хүмүүс нь тэгээд л ерөөсөө шууд шууд томилогдоод гардаг. Бүр 99 хувьтай гардаг. Тэр даргын хүн, хамаатан садан гэдгийг нь бүгд мэддэг ийм л увайгүй газар болчихоод байгаа шүү дээ.

Дарга нартаа үйлчилдэг, доошоо маш хатуу ийм газарт очиж байгаа шүү. Тийм учраас та нар бас энэ дээрээ анхаарч ажиллаарай гэж хэлье. Тэгээд ер нь бол намайг төрийн албаны зөвлөлийг шүүмжиллээ гээд, таныг хамгааллаа гээд Баярбаатар дарга аа, таныг дэмжих хүн бараг байхгүй дээ. Тэгээд хоёулаа зэрэгцүүлээд .../минут дуусав/

Ж.Бат-Эрдэнэ: Амарбаясгалан дарга үг хэлнэ.

Д.Амарбаясгалан: Юуны түрүүнд Төрийн албаны зөвлөлийн гишүүнд нэр дэвшиж орж ирж байгаа нөхдүүдэд бас амжилт хүсье.

Улсын Их Хурлын зүгээс нийтийн сонсголыг зохион байгуулж, шаардлага хангасан хүмүүсийн дунд сонсголыг бол албан ёсоор зохион байгуулж, томилж байгаа. Мэдээж орж ирсэн хүмүүстэй холбоотой асуудлууд байхыг бол үгүйсгэхгүй. Гишүүд энэ дээр байр сууриа илэрхийлээд явж байгаа гэж ингэж ойлгож байна. Зүгээр яах вэ, гишүүддээ бас энэ ташрамд товчхон хэлэхэд Улсын Их Хурлаар нээлттэй сонсгол зохион байгуулж томилдог орон тооны болон орон тооны бус Улсын Их Хуралд үйл ажиллагаагаа тайлагнадаг байгууллагуудын гишүүдийн асуудал байгаа. Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүн гэхэд 2, 3 удаа буцлаа. Тэгэхээр энэ дээр Улсын Их Хурал хариуцлага талаасаа бас харж, шалгуур шаардлага хангаж байгаа хүнийг бодлогоор Улсын Их Хурал бас дэмжиж явуулах тал дээр байх нь зөв болов уу гэсэн байдалтай байгаа.

Яагаад гэхээр байгууллагуудын үйл ажиллагаа хэвийн явагдахад доголдол үүсэх нөхцөл рүү Улсын Их Хурал асуудлаа шийдэж чадахгүй болохоор дагаж орж байгаа гэдгийг бас энэ ташрамд хэлье.

Зөвлөлийн гишүүнд нэр дэвшээд явж байгаа нөхдүүдэд бас энэ гишүүдийн хэлж байгаа үгийг их сайн анзаарч авах хэрэгтэй. Өмнө нь ч гэсэн Төрийн албаны зөвлөлд сонгогдож, томилогдож явж байгаа албан тушаалтнуудад гишүүд үг, захиасаа дайдаг. Харамсалтай нь өнөөдрийг хүртэл 10, 20 жил хэрэгжсэн зүйл байдаггүй. Ер нь Төрийн албаны зөвлөл өөрөө Их Хурлын дэргэд байж, Их Хурлын хяналтын чиг үүргийг гүйцэтгэх дээр голлон анхаарах ёстой байгууллага. Харамсалтай нь сүүлийн жилүүдэд төрийн албаны томилгоо гэдэг зүйл дээр анхаарлаа төвлөрүүлж ажилладаг болсон. Засгийн газар аль ч шатад ямар боловсон хүчнээр, ямар ажлыг даатгаж хийх вэ гэдэг асуудлыг өөрсдөө шийдэх

боломжгүйгээр Төрийн албаны зөвлөл энд шалгалт явуулж, сонгон шалгаруулж, томилгоо хийж байгаа байдал бол зүй зохистой зүйл биш юм.

Бусад өндөр хөгжилтэй улс орнуудын жишиг бол гүйцэтгэх засаглал өөрийнхөө хүний нөөцийн бодлогыг бариад явах боломжийг бүрдүүлснээр оршиж байдаг. Тэгээд Улсын Их Хурал дээр явж байгаа байгуулагдаад ажиллаж байгаа ажлын хэсэг энэ Төрийн албаны зөвлөлийг зөвхөн хяналтын чиг үүрэг дээрээ төвлөрч ажиллах нөхцөлөөр хангаж, хүний нөөцийнхөө бодлогыг гүйцэтгэх засаглал бүх төвшиндөө гаргаж явах нөхцөлийг нь бүрдүүлж өгөх чиглэл дээр бол хуулийн төсөл чиглэж явж байгаа юм. Тэгэхээр шинээр сонгогдож, томилогдож очиж байгаа та бүхэн Улсын Их Хурлын өөрчлөх гэж байгаа шинэ концепцыг эхнээсээ дэмжиж ажиллах үүргийг бас өнөөдөр өгөх нь зүйтэй гэж бодож байгаа юм.

Тэгээд энд байхаараа нэг өөрөөр, тэнд очихоороо бас ахиад өөрөөр бодож ерөөсөө болохгүй. Ер нь энэ төрийн албаны олон нийт дунд шүүмжлэгдэж байгаагийн үндсийн үндэс бол чадваргүй, оновчгүй боловсон хүчнийг оновчлолгүй газар байршуулсанд л үндсэндээ оршиж байдаг гэдгийг бас та бүхэн минь ойлгож, энэ хуулийн шинэчлэлийг хийхэд анхаарч ажиллаарай гэдгийг бас хэлье.

Ж.Бат-Эрдэнэ: Сандаг-Очир гишүүн үг хэлье гэж байна. Сандаг-Очир гишүүний микрофон өгье.

Ц.Сандаг-Очир: Баярлалаа. Юуны өмнө та 3-д амжилт хүсье. Түрүүнд Байнгын хороон дээр гишүүд асуулт асууж байсан. Ер нь энэ Төрийн албаны зөвлөлийн хараат бус байдлыг их яриад байгаа юм. Баахан л авлигад өртсөн хүмүүс байдаг юм шиг яриад байгаа юм. Харамсалтай нь тийм биш. Энэ байгууллагыг хэн тийм болгодог вэ гэхээр энэ дарга нар, сайд нар, гишүүд яг үнэнийг хэлэхэд өөрсдөө хуулиа зөрчиж, өөрсдөө Төрийн албаны зөвлөлийн гишүүдийг дарамталж, боловсон хүчнүүдээ томилдог юм шүү. Эд нар өөрсдөө яг ийм болгодог. Тэгчхээд дараа нь худлаа Төрийн албаны зөвлөлийнхөн хараат байдлаар ажилладаг, авлига, хээл хахууль авдаг гэсэн юм ярьдаг нь үнэн шүү дээ. Яг үнэнийг хэлэхэд. Та нар томилгоонд оролцоод байх юм бараг байхгүй болсон. Энэ хэдэн яамнууд чинь бүгдээрээ өөрсдөө Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлтэй. Түүгээрээ сонгон шалгаруулалтаа хийдэг. Та нар юу хийж байна вэ гэхээр хэдэн төрийн албан хаагчийн ерөнхий шалгалтыг, сонгон шалгаруулалтыг тусгай сонгон шалгаруулалтыг хийдэг. Ийм л болчихсон. Наад сайд нар чинь бүгд төрийн албаныхаа салбар зөвлөлийг яаман дээрээ авчихсан шүү дээ. Тэрэндээ өөрсдийнхөө жинхэнэ суганыхаа хүмүүсийг авчихсан. Дуртай хүмүүсээ дуртай үедээ халз сольдог. Энийг томил гэж дарамталдаг ийм болчихсон байхгүй юу. Худлаа ингээд жүжиглэцгээгээд Төрийн албаны зөвлөлийн хэдэн гишүүдийг дандаа ингээд авлигачин юм шиг нийгэмд ойлгуулах ийм юмыг яриад байгаа юм. Яг үнэнийг хэлэхэд хууль дүрмээ зөрчдөг хүмүүс нь энэ дарга, сайд нар өөрсдөө юм байгаа юм. Албан тушаалын томилгоо болох гэхээр тэрийг энд тавь, энийг ингэж дүгнэлтийг нь гаргаж өг ийм л шахаад явдаг шүү дээ яг үнэнийг хэлэхэд. Тэгээд энэнд нь таарсан хүнээ томилуулдаг. Үгээр нь байхгүй бол тэгээд л дарамталдаг ийм л байдалтай байгаа шүү дээ өнөөдөр яг үнэнийг хэлэхэд.

Тэгэхээр та 3 минь одоо гурвуулаа шинээр сонгогдож байна. Тийм учраас цаашдаа энэ бие даасан, хараат бус байдал дээр ажиллах тал дээрээ үнэхээр тэр Ардын нам нь байна уу, Ардчилсан нам нь байна уу, олон удаа сонгогдсон байна

уу, туршлагатай байна уу, шинэ байна уу үл хамаараад үнэхээр энэ ажлын байран дээр мэргэжил, боловсрол, мерит зарчмаараа, тэгээд нөгөө талаар хамгийн гол нь энэ цаг үед бол ёс зүйтэй хүн энэ төрийн албанд ажиллах ус агаар мэт хэрэгтэй байгаа шүү дээ. Ёс зүйн асуудал орхигдчихоод байгаа.

Өнөөдөр ямар ч төрийн албанд ажиллаагүй, эсвэл зарим нэг нь авлигын хуулиар ял эдэлсэн, шалгагдаж байгаа ийм хүмүүсийг хүртэл өнөөдөр томилчихсон асуудлууд байж байгаа шүү дээ. Яагаад ийм хүмүүсийг томилоод байдаг юм. Энэ чинь дандаа дарамтад орж томилогдож байгаа.

Нөгөө талаар тухайн яамныхаа харьяа төрийн албаны салбар зөвлөлөөрөө томилогдож байгаа. Аймгууд өөрсдийн салбар зөвлөлтэй, Нийслэл өөрөө салбар зөвлөлтэй, яамнууд өөрсдөө салбар зөвлөлтэй. Та нарын оролцоо тэр дээр бараг байхгүй. Ялыг нь харин та нар эдлээд .../минут дуусав/

Ж.Бат-Эрдэнэ: Гишүүд асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууслаа. Төрийн албаны зөвлөлийн гишүүнийг томилох, чөлөөлөх тухай асуудлаар санал хураалт явуулна. Гишүүд санал хураалтдаа бэлдье. Хуулийнхаа дагуу нууц санал хураалт явуулах ёстой.

Сонсгол дээр дэг зөрчсөндөө хүлцэл өчье. Хүлцэл өчсөн шүү.

1.Бүрэн эрхийн хугацаа нь дууссантай холбогдуулан Бадамцоогийн Идэрчулууныг Төрийн албаны зөвлөлийн гишүүнээс чөлөөлөхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалтад 15 гишүүнээс 11 гишүүн оролцож 73,3 хувиар санал дэмжигдлээ.

2.Бүрэн эрхийн хугацаа нь дууссантай холбогдуулан Должингийн Баатарсайханыг Төрийн албаны зөвлөлийн гишүүнээс чөлөөлөхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалтад 15 гишүүнээс 12 гишүүн оролцож, 80 хувиар санал дэмжигдлээ.

Бүрэн эрхийн хугацаа нь дууссантай холбогдуулан Цэнддаваагийн Амартөгсийг Төрийн албаны зөвлөлийн гишүүнээс чөлөөлөхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалтад 15 гишүүнээс 11 гишүүн оролцож, 73,3 хувиар санал дэмжигдлээ.

Одоо томилох санал хураалт явуулъя.

1.Лхагвасүрэнгийн Золзаяаг Төрийн албаны зөвлөлийн гишүүнээр томилохыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт санал хураалтад 15 гишүүнээс 11 гишүүн оролцож 73,3 хувиар санал дэмжигдлээ.

2.Цэнддаваагийн Амартөгсийг Төрийн албаны зөвлөлийн гишүүнээр томилохыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалтад 15 гишүүнээс 11 гишүүн оролцож, 73,3 хувиар санал дэмжигдлээ.

3.Бадамдоржийн Төгсцэнгэлийг Төрийн албаны зөвлөлийн гишүүнээр томилохыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал

хураалт. Санал хураалтад 15 гишүүнээс 12 гишүүн оролцож, 80 хувиар санал дэмжигдлээ.

Төрийн албаны зөвлөлийн гишүүний албан тушаалд нэр дэвшигчийн сонсголын тайланг хэлэлцэж дууслаа.

Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар чуулганы нэгдсэн хуралдаан танилцуулна. Төрийн байгуулалтын байнгын хорооны хэлэлцэх асуудал дууссан тул энэ өдрийн хуралдааныг хаасныг мэдэгдье.

15.45 цаг.

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ*

Э.СУВД-ЭРДЭНЭ